


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 04 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-16 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **1066** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1066 тохиолдлын 94% /998/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /68/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /5/, Төв/16/, Дорноговь /2/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 305 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **16** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.04.13 - 04.19)

2025 оны эпидемиологийн 16 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын **26** тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 66%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас 30%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-16 дугаар долоо хоногт нийт 299** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


151Эмнэлгийн
тусламж авч буцсан**148**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
46%Эмэгтэй
54%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 16 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **19** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 75%-аар буурсан бол сүүлийн 5 жилийн дунджтай ижил түвшинд байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 16 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	4	10	14
2	Эмийн хордлого	5	0	5
Нийт		9	10	19

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санамсаргүйгээр** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл ахуйн болон цэвэрлэгээний, машин, техникийн зориулалттай бүтээгдэхүүнүүдэд хордсон байна. **Санаатайгаар** өртсөн тохиолдлуудын 56%- ийг эрэгтэй, 44% -ийг эмэгтэй хүмүүс эзэлж байгаа бөгөөд 15-өөс 73 насныхан байна.

-o0o-